



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 115,752,006.05 (нэг зуун арван таван сая долоон зуун тавин хоёр мянга зургаан төгрөг таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 55,560,962.88 (тавин таван сая таван зуун жаран мянга есөн зуун жаран хоёр төгрөг наян найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг "Зам, тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэ, "Зам, тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Р.Буд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д оруулан бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001751

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 138  
 дугаар тогтоолын хавсралт

**Зам, тээврийн хөгжлийн яамны балансаас "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын  
 балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Налайх Тэрэлжийн Төлбөр хураах цэгийн байр	2006	ш	1	59,742,717.05	28,676,504.16	31,066,212.89
2	Рашаантын Төлбөр хураах цэгийн байр	2007	ш	1	56,009,289.00	26,884,458.72	29,124,830.28
				2	115,752,006.05	55,560,962.88	60,191,043.17
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>			<b>2 (хоёр)</b>	<b>115,752,006.05</b> (нэг зуун арван таван сая долоон зуун тавин хоёр мянга зургаан төгрөг таван мөнгө)	<b>55,560,962.88</b> (тавин таван сая таван зуун жаран мянга есөн зуун жаран хоёр төгрөг наян найман мөнгө)	<b>60,191,043.17</b> (жаран сая нэг зуун ерэн нэгэн мянга дөчин гурван төгрөг арван долоон мөнгө)